




Батлав:  С. Ламбаа
ЭМСЯ-ны Төрийн нарийн бичгийн
дарга, Эмнэлгийн мэргэжилтний
хөгжлийн зөвлөлийн дарга



Зөвшөөрсөн:  Р. Сандуйжав
ЭМСЯ-ны Хавдар судлалын мэргэжлийн
салбар зөвлөлийн дарга



**“БҮДҮҮН, ШУЛУУН ГЭДЭСНИЙ ХАВДРЫН МЭС ЗАСЛЫН ЧИГЛЭЛЭЭР
МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭХ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ ”**

Боловсруулсан:  Р.Ганбаатар / ХСҮТ-ийн Ерөнхий мэс заслын тасгийн
эрхлэгч, АУ-ны магистр/

Хянасан:  Г. Пүрэвсүрэн / ХСҮТ-ийн эрдэм шинжилгээ сургалт,
мэдээлэл эрхэлсэн дэд захирал , АУ-ны доктор /

Улаанбаатар хот

2016 он

БҮДҮҮН ШУЛУУН ГЭДЭСНИЙ ХАВДРЫН МЭС ЗАСЛЫН ЧИГЛЭЛЭЭР

НЭГ. УДИРТГАЛ ХЭСЭГ

ҮНДЭСЛЭЛ

Монгол улсад 2013 оны байдлаар 100000 хүнд амд бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын өвчлөл эмэгтэйчүүдэд 8,5, эрэгтэйчүүд 8.7 тохиолдол бүртгэгдэж байна. Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын нас баралт эмэгтэйчүүдэд 5,7 хувь, эрэгтэйчүүдэд 5,5 хувийн тархалттай байна¹.

Монгол улсын хүн амын дунд хорт хавдрын өвчлөл жил бүр өсөн нэмэгдэх хандлагатай байна. Тухайлбал 2004 онд 100000 эрэгтэй хүн амд 241 байсан бол 2013 онд 297 болж нэмэгдсэн байна. Сүүлийн жилүүдэд хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгааны нэг болсон зонхилон тохиолдох байрлалын хавдрын дотор бүдүүн, шулуун гэдэсний хавдрын эзлэх хувь нэмэгдсээр байна².

Иймд Хавдар судлалын үндэсний төв нь хорт хавдрын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг ялангуяа бүдүүн, шулуун гэдэсний хавдрын мэс заслын эмчилгээний чиглэлээр ажлын байранд сургах, дадлагажуулах ажлыг зохион байгуулж байна.

Хөтөлбөрийн зорилго: Ерөнхий мэс заслын мэргэжлийн эмч нарыг бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын мэс засал эмчилгээний чиглэлээр ажлын байранд дагалдуулан сургах замаар хорт хавдрын мэс заслын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах

Хөтөлбөрийн зорилт: Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын мэс заслын эмчилгээ, оношлогооны аргад суралцах

Сургалтын хэлбэр: Мэргэжил дээшлүүлэх сургалт

Элсэгчдэд тавигдах шаардлага: Анагаах ухааны бакалавраас доошгүй зэрэгтэй мэс заслын эмчийн мэргэжлийн үнэмлэхтэй хүний их эмч нараас шалгаруулж элсүүлнэ.

Агуулгын багтаамж: 20 багц цаг

Зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага:

1. Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын талаар эзэмшвэл зохих мэдлэг

1.1 Бүдүүн, шулуун гэдэсний анатоми, физиологи ба шинжилгээ

1.2 Бүдүүн, шулуун гэдэсний хавдрууд

- Бүдүүн, шулуун гэдэсний хоргүй (benign) болон хортой (malignant) хавдрын шинж тэмдэг, өвчний түүх,

1.3 Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын оношилгоо

- Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрыг багажын шинжилгээний тусламжтайгаар оношлох (Рентгэн шинжилгээ, дуран, КТГ)
- Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын үе шатыг гистологийн шинжилгээг оролцуулан тогтоох,

1 ХСҮТ, Хорт хавдрын тайлан, 2013

2 ХСҮТ, Хорт хавдрын тайлан, 2014

1.4 Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын эмчилгээ

1.4.1 Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын эмчилгээний төрлүүд

- Хавдрын эмийн эмчилгээний сонголт, заалт, үр дүн, мэс заслын ба мэс заслын бус эмчилгээний эрсдэл ба давуу талыг оролцуулан тооцох,
- Бүдүүн, шулуун гэдэсний хортой хавдруудын адювант, нео-адьювант, хими болон туяа эмчилгээний үүрэг

14.2 Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын мэс заслын эмчилгээ

- Хагалгааны өмнөх өвчтөнийг үнэлэх, төлөвлөсөн хагалгааны эрсдэлийг үнэлэх
- Бүдүү, шулуун гэдэсний тайралтын техникийн төрлүүд
- Бүдүүн, шулуун гэдэсний үйл ажиллагааны нөөцийг тогтоох аргууд
- Мэс заслын өмнөх менежмент
- Мэс заслын үеийн менежмент
- Мэс заслын дараах менежмент ба хүндрэл

2. Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын талаар эзэмшвэл зохих чадвар:

2.1 Бүдүүн, шулуун гэдэсний анатоми, физиологи ба шинжилгээ

- Хэвийн анатомын бүтэц, аномали, эмгэг бүтцүүдийг таних чадвартай болох
- Бүдүүн, шулуун гэдэсний ойролцоох бүтцийг таньж, тодорхойлох

2.2 Бүдүүн, шулуун гэдэсний хавдрууд

- Мэс заслын үед бүдүүн, шулуун гэдэсний дурангийн шинжилгээ хийж дүгнэх
- Бүдүүн, шулуун гэдэсний хоргүй хавдартай өвчтөнийг үнэлэх
- Бүдүүн, шулуун гэдэсний хоргүй хавдартай өвчтөний менежмент
- Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдартай өвчтөнийг үнэлэх
- Бүдүүн, шулуун гэдэсний анхдагч ба хоёрдогч аденокарцином ба бусад метастатик үүсгэвэртэй өвчтөнүүдийг үнэлэх

2.3 Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын оношилгоо

- Гематологи ба биохимийн шинжилгээнд дүгнэлт хийх
- Бүдүүн, шулуун гэдэсний хавдар, үүсгэвэрүүдийг багажын шинжилгээний тусламжтайгаар оношлох, үе шатыг тодорхойлох (Рентгэн, дуран, КТ)

2.4 Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын мэс заслын ба мэс заслын бус эмчилгээ

- Бүдүүн, шулуун гэдэсний хагалгаанд орох өвчтөнийг үнэлэх (хавсарсан болон дагалдах өвчин)
- Мэс заслын өмнөх лаборатори шинжилгээ ба багажийн шинжилгээнд тулгуурлан, мэс заслын стратегийг төлөвлөх
- Дурангийн хагалгааны үед эмчлүүлэгчийг зөв байрлуулах, хагалгааны өмнөх бэлтгэл
- Бүдүүн, шулуун гэдэсний мэс заслын үед хийгдэх оновчтой хувилбарыг сонгох
- Мэс заслын үед хавдрын үе шатыг тогтоох (I/O US оролцуулан)
- Олон төрлийн аргачлал ашиглан, бүдүүн, шулуун гэдэсийг тайрах
- Бүдүүн, шулуун гэдэсийг бусад хэсгүүдийг оролцуулсан хавсарсан тайралт хийх
- Бүдүүн, шулуун гэдэсний тайралтын өмнөх ба дараах үеийн эмчилгээ ба хүндрэлийн менежмент
- Бүдүүн, шулуун гэдэс тайруулсан өвчтөний мэс заслын дараах эрт ба хожуу үеийн менежмент, хүндрэлийг оношлох

- Бүдүүн, шулуун гэдэсний тайралтын дараах үеийн хими ба туяа эмчилгээ
- Тайрагдах боломжгүй бүдүүн, шулуун гэдэсний хортой хавдрын үед хийгдэх эмчилгээ

3. Зайлшгүй эзэмшвэл зохих хандлага: Монгол улсын хууль тогтоомж, эрүүл мэндийн салбарын эрх зүйн орчинд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг баримтлан чанартай ээлтэй тусламж, үйлчилгээг үзүүлэхэд шаардлагатай дадлыг эзэмших

ХҮСНЭГТ 1.

БАГШЛАХ БОЛОВСОН ХҮЧНИЙ БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог нэр	Мэргэжлийн зэрэг	Боловсролын зэрэг	Ажилласан жил
1.	Янсан Эрдэнэ-очир	ХСҮТ-ийн Мэс заслын клиникийн зөвлөх, мэс заслын тэргүүлэх зэргийн эмч	АУ-ны доктор	26 жил
2.	Рэнцэнбалбар Ганбаатар	ХСҮТ-ийн Ерөнхий мэс заслын тасгийн эрхлэгч, мэс заслын тэргүүлэх зэргийн эмч	-	20 жил
3.	Дүнтээ Жаргалсайхан	ХСҮТ-ийн Ерөнхий мэс заслын тасгийн эмч, мэс заслын тэргүүлэх зэргийн эмч	-	22 жил
4.	Чулуун Сарантулга	ХСҮТ-ийн Ерөнхий мэс заслын тасгийн их эмч, мэс заслын ахлах зэргийн эмч	-	10 жил

ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын мэс заслын чиглэлээр мэргэжил дээшлүүлж байгаа эмч дараах сургалтын агуулга бүхий хөтөлбөрийн хүрээнд суралцана.

Сургалтын хөтөлбөр нь 2 үндсэн хэсэгтэй.

1. Бүдүүн гэдэсний хавдрын оношилгоо, эмчилгээ
2. Шулуун гэдэсний хавдрын оношилгоо, эмчилгээ

1. Бүдүүн гэдэсний хавдрын оношилгоо, эмчилгээ хөтөлбөрийн агуулга:

- 1.1 Бүдүүн гэдэсний анатоми, физиологи ба шинжилгээ
- 1.2 Бүдүүн гэдэсний хоргүй (benign) болон хортой (malignant) хавдрын тархвар зүй, шинж тэмдэг, өвчний түүх цуглуулах, анхан шатны үзлэг хийх клиникийн чадвар
- 1.3 Бүдүүн гэдэсний үйл ажиллагаатай холбоотой лаборатори, гематологи, биохимийн шинжилгээний үзүүлэлтүүд тэдгээрийг дүгнэх
- 1.4 Бүдүүн гэдэсний хавдрыг багажын шинжилгээний тусламжтайгаар оношлох, үе шатыг гистологийн шинжилгээг оролцуулан тогтоох,
- 1.5 Бүдүүн гэдэсний үйл ажиллагааны нөөцийг тогтоох аргууд
- 1.6 Бүдүүн гэдэсний хавдрын эмчилгээ
 - 1.6.1 Бүдүүн гэдэсний хавдрын эмчилгээний менежмент (Хавдрын эмийн эмчилгээний сонголт, заалт, үр дүн, мэс заслын ба мэс заслын бус

- эмчилгээний эрсдэл, давуу талыг тооцох, бүдүүн гэдэсний хортой хавдруудын адювант, нео-адьювант, хими болон туяа эмчилгээний үүрэг)
- 1.6.2 Мэс заслын өмнөх өвчтнийг үнэлэх, өвчтөний шинжилгээ ба дүрс оношлогоонд тулгуурлан мэс заслын стратегийг төлөвлөх, төлөвлөсөн мэс заслын эрсдэлийг үнэлэх, КТ-аар бүдүүн гэдэсний эзэлхүүнд илрэх өөрчлөлтүүдийг тодорхойлох
- 1.6.3 Бүдүүн гэдэсний хавдрын мэс заслын эмчилгээ (Мэс заслын өмнөх өвчтөнийг үнэлэх, төлөвлөсөн мэс заслын эрсдэлийг үнэлэх, бүдүүн гэдэсний тайралтын техник, мэс заслын өмнөх, мэс заслын үеийн болон мэс дараах менежмент ба хүндрэл)
- 1.6.4 Бүдүүн гэдэсний хагалгааны үед хийгдэх зүслэгийг оновчтой сонгож сурах Бүдүүн гэдэсний өгсөх, хөндлөн, уруудах хэсэгт байрлалтай хорт хавдрын тайралтын техникийн төрлүүд
- 1.6.5 Бүдүүн гэдэсний хортой хавдрын үеийн дурангийн мэс заслын эмчилгээ, дурангийн мэс заслын өмнөх менежмент
- 1.5.6 Бүдүүн гэдэсний хожуу үеийн хорт хавдартай өвчтөний хөнгөвчлөх мэс заслын үеийн мэс заслын өмнөх, мэс заслын үеийн, мэс заслын дараах менежмент

2. Шулуун гэдэсний хавдрын оношилгоо, эмчилгээ хөтөлбөрийн агуулга:

- 2.1 Шулуун гэдэсний анатоми, физиологи ба шинжилгээ
- 2.2 Шулуун гэдэсний хоргүй (benign) болон хортой (malignant) хавдрын тархвар зүй, шинж тэмдэг, өвчний түүх,
- 2.3 Шулуун гэдэсний үйл ажиллагаатай холбоотой лаборатори, гематологи, биохимийн шинжилгээний үзүүлэлтүүд тэдгээрийг дүгнэх
- 2.4 Шулуун гэдэсний хавдрыг багажын шинжилгээний (Рентген, дуран, КТГ) тусламжтайгаар оношлох, үе шатыг гистологийн шинжилгээг оролцуулан тогтоох,
- 2.5 Шулуун гэдэсний үйл ажиллагааны нөөцийг тогтоох аргууд
- 2.6 Шулуун гэдэсний хавдрын эмчилгээ
 - 2.6.1 Шулуун гэдэсний хавдрын эмчилгээний менежмент (Хавдрын эмийн эмчилгээний сонголт, заалт, үр дүн, мэс заслын ба мэс заслын бус эмчилгээний эрсдэл, давуу талыг тооцох, ходоодны хортой хавдруудын адювант, нео-адьювант, хими болон туяа эмчилгээний үүрэг)
 - 2.6.2 Мэс заслын өмнөх өвчтнийг үнэлэх, өвчтөний шинжилгээ ба дүрс оношлогоонд тулгуурлан, мэс заслын стратегийг төлөвлөх, төлөвлөсөн мэс заслын эрсдэлийг үнэлэх, КТ-аар шулуун гэдэсний эзэлхүүнд илрэх өөрчлөлтүүдийг тодорхойлох
 - 2.6.3 Шулуун гэдэсний хавдрын мэс заслын эмчилгээ (Мэс заслын өмнөх өвчтөнийг үнэлэх, төлөвлөсөн мэс заслын эрсдэлийг үнэлэх, бүдүүн гэдэсний тайралтын техник, мэс заслын өмнөх, мэс заслын үеийн болон мэс дараах менежмент ба хүндрэл)
 - 2.6.4 Шулуун гэдэсний мэс заслын үед хийгдэх зүслэгийг оновчтой сонгох, шулуун гэдэсний дээд, дунд, доод хэсэгт байрлалтай хорт хавдрын үеийн тайралтын техникийн төрлүүд, мэс заслын үеийн менежмент
 - 2.6.5 Шулуун гэдэсний хортой хавдрын үеийн дурангийн мэс заслын эмчилгээ,

- 2.6.6 дурангийн мэс заслын өмнөх менежмент
Хоол боловсруулах замын хожуу үеийн хорт хавдартай өвчтөний хөнгөвчлөх мэс заслын үеийн мэс заслын өмнөх, мэс заслын үеийн, мэс заслын дараах менежмент

ГУРАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

Мэргэжил дээшлүүлэх сургалт нь суралцагч төвтэй сургалтын технологид тулгуурлан, бие даан суралцах үйл ажиллагааг дэмжих, бүдүүн, шулуун гэдэсний хавдрын мэс заслын салбарт нь чиглүүлэх, бололцоо нөхцлөөр хангахад чиглэнэ.

1. Онолын лекц танхимд, мэс засал, онош зүй, лаборатори, эмгэг судлал, хүлээн авах, эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн тасаг, амбулаторит дадлага хийх, семинар хийх зэрэг сургалтын олон аргыг ашиглан сургалт явуулна. Мөн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд багаар ажиллах мэргэжлийн үр чадвартай болоход тусална.
2. Суралцагчдыг сэтгэн бодох, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга барилд сургана.
3. Сургалтын нийт цагийн харьцаа нь лекц: дадлага: семинар 20:40:40 байхаар төлөвлөгдсөн байна.

Лекц: Онолын шинэ мэдээлэл, эмнэлзүйн лекц 10 хувь, санаа бодлоо харилцан солилцох интерактив лекц 90 хувь байхаар төлөвлөгдөнө.

Дадлага: Эмч багш, тасгийн эрхлэгчийн удирдлагад тойрон ажиллах, үйлчлүүлэгчидтэй ажиллах, асуудлыг хамтран шийдвэрлэх, эмнэлзүйн сургалт тасаг, поликлиникт хийгдэнэ.

Семинар: Семинарын хичээл нь эмч нарын яриа, зөвлөгөөн, тохиолдлын танилцуулга, эмч нарын хамтарсан үзлэг, журнал, клуб зэрэг хэлбэрээр явагдана.

ЛЕКЦИЙН ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хичээлийн нэр	Цаг
1.	Бүдүүн, шлууун гэдэсний анатоми, физиологи ба шинжилгээ	3
2.	Бүдүүн гэдэсний өгсөх, хөндлөн, гарах хэсэг болон шулуун гэдсэнд байрлалтай хорт хавдрын оношлогоо, шинжилгээ	3
3.	Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын тархвар зүй	3
4.	Бүдүүн, шулуун гэдсэнд байрлалтай хорт хавдрын үеийн тайралтын техникийн төрлүүд, хагалгааны өмнөх өвчтөнийг үнэлэх, төлөвлөсөн хагалгааны эрсдлийг үнэлэх, КТГ-аар бүдүүн, шулуун гэдэсний бүтэц, эзлэхүүнд тус тус илрэх өөрчлөлтүүдийг тодорхойлох	3
5.	Хоол боловсруулах доод замын үйл ажиллагааны нөөцийг тогтоох аргууд, бүдүүн, шулуун гэдсэнд байрлалтай хорт хавдартай өвчтөний мэс заслын өмнөх менежмент ба хүндрэл	3
6.	Бүдүүн, шулуун гэдсэнд байрлалтай хорт хавдартай өвчтөний мэс заслын үеийн, мэс заслын дараах менежмент ба хүндрэл	3
7.	Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын шинж тэмдэг болон түүх, хавдрын оношилгооны үр дүнтэй процедурыг сонгох	3
8.	Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын үе шатыг гистологийн шинжилгээ оролцуулан тогтоох	3
9.	Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын эмчилгээний сонголт, заалт, үр дүн, мэс заслын ба мэс заслын бус эмчилгээний эрсдэл ба давуу талыг оролцуулан тооцох	3
10.	Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын мэс заслын өмнөх, мэс заслын үеийн, мэс заслын дараах менежмент, мэс заслын хүндрэлийг тооцох	3
11.	Бүдүүн, шулуун гэдэсний хортой хавдрын нео-адювант, адювант, хими, туяа эмчилгээний үүрэг	3
12.	Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын үеийн дурангийн мэс заслын эмчилгээ, дурангийн мэс заслын өмнөх менежмент	3
13.	Дурангийн мэс заслын үед эмчлүүлэгчийг зөв байрлуулах, трокарыг зөв байрлуулах, бүдүүн гэдэсний өгсөх хэсэгт байрлалтай хавдрын үед дурангийн аргаар хийх тайралтын техникийн төрлүүд	3
14.	Бүдүүн гэдэсний хөндлөн, уруудах хэсэгт байрлалтай хавдрын үед дурангийн аргаар хийх тайралтын техник, дурангийн мэс заслын өмнөх өвчтөнийг үнэлэх, төлөвлөсөн хагалгааны эрсдлийг үнэлэх	3
15.	Бүдүүн, шулуун гэдэсний хожуу үеийн хорт хавдартай өвчтөний хөнгөвчлөх мэс заслын өмнөх, мэс заслын үеийн болон мэс заслын дараах менежмент	3
16.	Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын хожуу үеийн хөнгөвчлөх мэс ажилбар, техникийн төрлүүд	3
	Нийт цаг	48
	Эзлэх хувь	20
	Багц цаг	4,0

ХҮСНЭГТ 3.**СЕМИНАРЫН ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/ д	Хичээлийн нэр	Ца г
1.	Хоол боловсруулах доод замын анатоми, физиологи ба шинжилгээ	12
2.	Бүдүүн гэдэсний өгсөх, хөндлөн, гарах хэсэг болон шулуун гэдсэнд байрлалтай хорт хавдрын оношлогоо, шинжилгээ	12
3.	Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын тархвар зүй, өвчлөл, нас баралтын бүтцэд дүгнэлт хийх	12
4.	Бүдүүн гэдэсний өгсөх, хөндлөн, гарах хэсэг болон шулуун гэдсэнд байрлалтай хорт хавдрын үеийн тайралтын техникийн төрлүүд, хагалгааны өмнөх өвчтөнийг үнэлэх, төлөвлөсөн хагалгааны эрсдлийг үнэлэх, КТГ-аар ходоодны бүтэц, эзлэхүүнд тус тус илрэх өөрчлөлтүүдийг тодорхойлох	12
5.	Хоол боловсруулах доод замын үйл ажиллагааны нөөцийг тогтоох аргууд, бүдүүн, шулуун гэдсэнд байрлалтай хорт хавдартай өвчтөний мэс заслын өмнөх менежмент ба хүндрэл	12
6.	Бүдүүн, шулуун гэдсэнд байрлалтай хорт хавдартай өвчтөний мэс заслын үеийн, мэс заслын дараах менежмент ба хүндрэл	12
7.	Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын шинж тэмдэг болон түүх, хавдрын оношилгооны үр дүнтэй процедурыг сонгох	12
8.	Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын үе шатыг гистологийн шинжилгээ оролцуулан тогтоох	12
9.	Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын эмчилгээний сонголт, заалт, үр дүн, мэс заслын ба мэс заслын бус эмчилгээний эрсдэл ба давуу талыг оролцуулан тооцох	12
10.	Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын мэс заслын өмнөх, мэс заслын үеийн, мэс заслын дараах менежмент, мэс заслын хүндрэлийг тооцох	12

11.	Бүдүүн, шулуун гэдэсний хортой хавдрын нео-адювант, адювант, хими, туяа эмчилгээний үүрэг	12
12.	Бүдүүн, шулуун гэдэсний хавдрын үеийн дурангийн мэс заслын эмчилгээ, дурангийн мэс заслын өмнөх менежмент	12
13.	Дурангийн мэс заслын үед эмчлүүлэгчийг зөв байрлуулах, трокарыг зөв байрлуулах, бүдүүн гэдэсний өгсөх хэсэгт байрлалтай хавдрын үед дурангийн аргаар хийх тайралтын техникийн төрлүүд	12
14.	Бүдүүн, гэдэсний хөндлөн болон уруудах хэсэгт байрлалтай хавдрын үед дурангийн аргаар хийх тайралтын техникийн төрлүүд, дурангийн мэс заслын өмнөх өвчтөнийг үнэлэх, төлөвлөсөн хагалгааны эрсдлийг үнэлэх	12
15.	Бүдүүн, шулуун гэдэсний хожуу үеийн хорт хавдартай өвчтөний хөнгөвчлөх мэс заслын өмнөх, мэс заслын үеийн, мэс заслын дараах менежмент	12
16.	Бүдүүн гэдэсний өгсөх, хөндлөн, гарах хэсэг болон шулуун гэдэсний хорт хавдрын хожуу үеийн хөнгөвчлөх мэс ажилбар, техникийн төрлүүд	12
	Нийт цаг	192
	Эзлэх хувь	40
	Багц цаг	8,0

ХҮСНЭГТ 4.

ДАДЛАГЫН ХИЧЭЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

д/д	Хичээлийн нэр	Цаг
1.	Бүдүүн гэдэсний өгсөх, хөндлөн, гарах хэсэг болон шулуун гэдсэнд байрлалтай хорт хавдрыг багажын шинжилгээний тусламжтайгаар оношлох (Рентген шинжилгээгээр байрлалыг тогтоох, КТГ-аар ходоод, нарийн бүтэц, эзлэхүүнд тус тус илрэх өөрчлөлтүүдийг тодорхойлох)	12
2.	Бүдүүн гэдэсний өгсөх, хөндлөн, гарах хэсэг болон шулуун гэдсэнд байрлалтай хорт хавдрын үе шатыг гистологийн шинжилгээ оролцуулан тогтоох	12
3.	Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын тархвар зүйд дүн шинжилгээ хийх, хүн амын өвчлөл, нас баралтын түвшинг хүснэгт, зургаар илэрхийлэх	12
4.	Бүдүүн гэдэсний өгсөх, хөндлөн, гарах хэсэг болон шулуун гэдсэнд байрлалтай хорт хавдрын мэс заслын тайралтын техникийн төрлүүд, мэс заслын өмнөх өвчтөнийг үнэлэх, төлөвлөсөн хагалгааны эрсдлийг үнэлэх, хоол боловсруулах доод замын үйл ажиллагааны нөөцийг тогтоох аргууд	24
5.	Бүдүүн гэдэсний өгсөх, хөндлөн, гарах хэсэг болон шулуун гэдсэнд байрлалтай хорт хавдартай өвчтөний мэс заслын өмнөх, мэс заслын үеийн, мэс заслын дараах үед тохиолдох хүндрэл, түүнээс сэргийлэх	12
6.	Бүдүүн гэдэсний өгсөх, хөндлөн, гарах хэсэг болон шулуун гэдэсний хавдрын шинж тэмдэг бүхий өвчтөнд үзлэг хийх, биеийн байдалд үнэлгээ өгөх, өвчний түүх нээх, эмчилгээний төлөвлөгөө боловсруулах	12
7.	Эмч нарын тойрон үзлэг, зөвлөгөөнд хүнд өвчтөнийг танилцуулах, хамтарсан шийдвэр гаргах, ховор тохиолдлыг хэлэлцэх	24
8.	Бүдүүн гэдэсний өгсөх, хөндлөн, гарах хэсэг болон шулуун гэдэсний	12

	хортой хавдрын нео-адювант, адювант, хими, туяа эмчилгээ	
9.	Ходоод, нарийн гэдэсний хавдрын үеийн дурангийн мэс заслын эмчилгээ, ходоодны орох хэсэг, их бие, гарах хэсэг нарийн гэдсэнд байрлалтай хорт хавдартай өвчтөний дурангийн мэс заслын өмнөх менежмент	12
10.	Дурангийн мэс заслын үед эмчлүүлэгчийг зөв байрлуулах, трокарыг зөв байрлуулах, бүдүүн гэдэсний өгсөх хэсэгт байрлалтай хавдрын үед дурангийн аргаар хийх тайралтын техникийн төрлүүд	18
11.	Бүдүүн гэдэсний хөндлөн, гарах хэсэг болон шулуун гэдсэнд байрлалтай хавдрын үед дурангийн аргаар хийх тайралтын техникийн төрлүүд, дурангийн мэс заслын өмнөх өвчтөнийг үнэлэх, төлөвлөсөн хагалгааны эрсдлийг үнэлэх	18
12.	Бүдүүн, шулуун гэдэсний хожуу үеийн хорт хавдартай өвчтөний хөнгөвчлөх мэс заслын мэс заслын өмнөх, мэс заслын үеийн болон мэс заслын дараах менежмент	12
13.	Бүдүүн, шулуун гэдэсний хорт хавдрын хожуу үеийн хөнгөвчлөх мэс ажилбар буюу хавдрыг алгасуулан залгах мэс ажилбар, техникийн төрлүүд	12
	Нийт цаг	192
	Эзлэх хувь	40
	Багц цаг	8,0

ДӨРӨВ. СУРГАЛТЫН ҮНЭЛГЭЭ

1. Мэдлэг, чадвар, хандлагын түвшинг сорил, бичиглэл, ярилцлага, бодлого зэрэг шалгалтын оновчтой хэлбэрийг ашиглан тогтооно.
2. Мэс засал, онош зүй, лаборатори, эмгэг судлал, хүлээн авах, эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн тасгуудад ажиллан, тухайн сэдвээр шүүлэг авч **хөтөлбөрийн шаардлагыг 80 хувиас дээш** хангасан тохиолдолд шалгалтанд оруулна.
3. Төгсөлтийн шалгалтыг **онол ба ур чадвар, хандлага** гэсэн хоёр чиглэлээр авах ба онолын шалгалтыг сорил, бодлого, ярилцлага хэлбэрээр, ур чадвар ба хандлагын шалгалтыг сургалтын явц болон төгсгөлд тасаг, амбулаторид ажиллах, гардан үйлдэл хийх ур чадварыг шалган үнэлнэ.
4. Төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэхдээ үсэг, тоо, рейтингээр дүгнэн дүнг гарган тогтооно.

ХҮСНЭГТ 5.

ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ

№	Хувиар	Үсгэн үнэлгээ	Оноо (0-4)	Үнэлгээний болзол
1	90-100	A	4.0	Тухайн хичээлийн агуулгыг бүрэн бүтээлчээр ойлгож, мэдлэг эзэмшсэн, эзэмшсэн мэдэлгээ чадварлаг ашиглаж чаддаг байх

2	80-89	B	3.0	Тухайн хичээлийн агуулгыг сайн ойлгож, мэдлэг эзэмшсэн, эзэмшсэн мэдэлгээ үйл ажиллагаандаа хэрэглэж чаддаг байх
3	70-79	C	2.0	Тухайн хичээлийн агуулгыг хангалттай хэмжээний ойлголт, авсан, холбогдох энгийн даалгаварыг хийж гүйцэтгэх чадвартай бөгөөд цаашдаа тухайн хичээлийг гүнзгийрүүлэн судлах бэлтгэлтэй болсон байх
4	60-69	D	1.0	Тухайн хичээлийн агуулгыг жигд ойлгоогүй харьцангуй хялбар ажилбаруудыг хийж гүйцэтгэх чадвартай бөгөөд цаашдаа тухайн хичээлийг гүнзгийрүүлэн судлахын тулд нэмэлт даалгавар хийж гүйцэтгэх шаардлагатай
5	0-59	F	0.0	Мэдлэг, чадвар, дадал хангалтгүй байх

ХҮСНЭГТ 6.

СЕМИНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Огноо:

Резидентийн нэр:

Семинарын сэдэв:

Оноо: 4-Маш сайн, 3-Сайн, 2-Дундаж, 1-Дундаас доогуур, 0-Муу

Үнэлгээний үзүүлэлтүүд:	Оноо
Танилцуулга	
Үзүүлэн	
Хичээлдээ бүрэн бэлтгэж ирсэн эсэх	
Дуу ба дүрс бичлэг ашиглах	
Сэдвээ ойлгосон байдал	
Асуултад хариулах чадвар	
Цаг ашиглалт	
Холбогдох ном хэвлэлд үнэлгээ өгөх, хэлэлцүүлэг хийх	
Дундаж оноо	

АШИГЛАХ НОМ, ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ

1. Гарин А. М., Хлебнов А. В., Табагари Д. З., Справочник по противоопухолевой лекарственной терапии . М., Медицина , 1993
2. Даръалова С. Л., Чиссов В.И., Диагностика и лечение злокачественных опухолей. М., Медицина, 1993, с 225
3. Диагностика и лечение онкоурологических заболеваний . Сборник трудов . вып . 11, под ред . Матеева Б. П М., Медицина 1991
4. Дурнов Л.А., Голдобенко Г.В., Сигел Ст. Э,Настольная книга детского онколога . М., Параллель, 1994
5. Дымарский Л. Ю. Рак молочной железы . Библ. Практического врача . Злокачественные новообразования . М., Медицина, 1980
6. Заризде Д. Г., Пито Р. Курение и здоровье. М. Медицина, 1989
7. Заризде Д. Г., Букин Ю. В., Драудин-Крыленко В. А., Связь между характером патологических изменений слизистой оболочки пищевода и дефицитом некоторых витаминов в популяции с высокой частоты рака пищевода. Вопр. Онкологии . '8, 1989, 939-945
8. Иммуноцитохимия и моноклональные антитела в онкологии . Под ред . Пинчука В.Г. и Глузмана Д. Ф. Киев , Наукова думка . 990.
9. Кампова Ф.Л., Павлыш О. А., Татосян А. Г . Молекулярны основы канцерогенеза у человека . М., Медицина.1990
10. Трахтенбург А. Х., Рак легкого . М., Медицина., 1987.2002
11. Федоров В.Д., идр. Проктология . М., Медицина.1984
12. Черенков В. Г., Клиническая онкология . Москва., 1999
13. Черкес В.Л., и др. Забрюшинные внеорганные опухоли. М., медицина. 1976.
14. Шабод Л. М., Эволюция концепций бластомогенеза.М.,1979.
15. Шипиллов В. И., Рак мочевого пузыря ., Медицина, 1983.
16. Ярмоненко с.П., Коноплянников А.Г., Вайнсон А.А. Клиническая радибиология . М., Медицина, 1992, с . 316
17. Bodmer W., Zaridze D. G., Cancer Prevention in Europe Proceedings of international Meeting. Moscow , 2-4 September.1991.
18. Rhoda H.Cobin –David King Sirota . Malignant Tumors of the Thyroid . New York, No 4, USA, 1992.
19. Martin D. Abeleff , James O. Armitage , Allen S. Lighter , John E .Neiderhaber 'Clinical Oncology ' New york , Edinburgh , London , Melbourne , Tokyo . 1995

Вэб сайт:

1. Эрүүл мэндийн яам www.moh.mn
2. ХСҮТ www.cancer-center.gov.mn
3. ДЭМБ www.who.com
4. ЭМХТ www.chd.moh.mn
5. www.legalinfo.mn
6. <http://www.who.int/hinari>
7. <http://www.medscape.com/>

